



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

Додд оны *03* сарын *07* өдөр

Дугаар *8/3.*

Өлгий

Г Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсгийг, 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргээ биелүүлээгүй асуудлыг шалган тогтоож, шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй гурван жилийн хугацаатай байгуулсугай.

Зөвлөлийн дарга

Ж.Естай Газрын удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд

Х.Айнур Захиргаа, хуулийн асуудал хариуцсан

мэргэжилтэн

Т.Баатар Газрын татвар, төлбөр үнэлгээний
асуудал хариуцсан мэргэжилтэн

2. “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталж хэрэгжүүлэн ажиллахыг Ёс зүйн зөвлөлд даалгасугай.

ДАРГА

К.БОЛАТ

